

О калмыцких хошутах (Халимагийн хошуудууд) On the Khoshuts of Kalmykia

*Норовсамбуу Наранжаргал (Norovsambuu Naranjargal)*¹

¹ аспирант, Монгольский государственный педагогический университет (г. Улан-Батор, Монголия). E-mail: naranjargal_85@yahoo.com
Postgraduate Student, Mongolian State Pedagogical University (Ulaanbaatar, Mongolia). E-mail: naranjargal_85@yahoo.com

Аннотация. В данной статье автор рассматривает некоторые вопросы истории сложения одного из калмыцких этносов — хошутов. На основе данных исторических источников, архивных материалов, научной литературы автор описывает страницы истории хошуты, начиная со времени их откочевки в 1663 г. во главе с Кундулен-Убаши из Джунгарии, — где начал свое правление хан Галдан, — на Волгу. Несмотря на наличие сильного войска у хошутского Аблай-тайши исходом его борьбы с ханом Аюки было включение хошуты в состав Калмыцкого ханства.

В статье приводится родословная хошутских нойонов Калмыкии, начиная с Хан-нойона Хонгора, потомка младшего брата Чингисхана Хавт Хасара в десятом поколении. Особое место отводится в статье описанию событий, связанных с именем хошутского нойона Джамьяна (Замьяна), чья родословная восходит к младшему брату Байбагас-батыра Дзасакту-Чинбатару. После откочевки в 1771 г. части хошуты в Джунгарию вместе с Убаши-ханом оставшиеся калмыцкие семьи по приказу Екатерины II были переданы во владение нойону Джамьяну за его преданность. После смерти Джамьяна хошутами стал управлять его пасынок Тумэнджаргал, затем его сыновья Серебджаб Тюмень и Батыр Убаши Тюмень.

Автор приводит богатый материал, освещающий самые разные страницы истории хошуты Калмыкии: образование аймаков, открытие школы, участие в войнах, годы ссылки, административные реформы и т. п.

Ключевые слова: история, калмыки, субэтнос, хошуты, исторические источники, архивные материалы, Джунгария, Калмыцкое ханство.

Abstract. The article examines some issues on the history of the genesis of the Kalmyk ethnic subgroup — Khoshuts. With evidence from historical sources, archival materials, scholarly literature, the study depicts the history of the Khoshuts from the time of the 1663 Kundulen Ubashi-led decampment from

Dzungaria (where Galdan Khan's rule had began) towards the Volga. Despite the fact Ablai Taishi of the Khoshuts had considerable military forces under his command, his struggle with Ayuka Khan resulted in the annexation of his people to the Kalmyk Khanate.

The article draws on the genealogical table of the Khoshut noyons (princes) of Kalmykia that begins with Khan Noyon Khongor — a 10th generation descendant of Habutu Hasar, Genghis Khan's younger brother. Special attention is paid to the description of the events connected with the Khoshut Noyon Jamyang (Zamyan) who claimed descent from Baibagas Baghatur's younger brother — Dzasagtu Chinbaatar. After the 1771 Ubashi Khan-led exodus of Kalmyks, the remaining Khoshut clans, by Catherine the Great's order, were assigned to the property of Noyon Jamyang as a reward for the loyalty of the latter. After Jamyang's death, the Khoshuts were ruled by his stepson Tyumenjargal who was succeeded in the position by his sons Serebjab Tyumen and Baatar Ubashi Tyumen.

The author draws on rich research materials to depict in detail the history of the Khoshuts of Kalmykia: the establishment of aimags (settlements), opening of the school, participation in wars, years of deportation, administrative reforms, etc.

Keywords: history, Kalmyks, sub-ethnic group, Khoshuts, historical sources, archival materials, Dzungaria, Kalmyk Khanate.

Халимагийн хошуудуудыг тусгайлан судласан судалгааны бүтээл одоохондоо байхгүй бөгөөд эрдэмтэн В.П. Санчилов [Санчилов 1977 и др.], Г.О. Авляев [Авляев, Санчилов 1984] нарын бүтээлд цухас төдий дурдагдсан. 2000 онд Халимагийн хүмүүнлэгийн судалгааны хүрээлэнгээс хошуудын оршин суудаг Кетченер, Сарпин, Малодербет, Октябрь зэрэг районуудаар угсаатаны судлагаа хийж, үр дүнд нь тэдний угийн бичгийн эмхэтгэлийг хэвлэн гаргажээ [Генеалогия 2011].

Халимаг дахь хошуудуудын бүрдэл ба тэдний ноёдын угсаа гарал

Хошуудууд нь Ойрадын нутгийн өмнөд хэсгээр нутаглаж байгаад ихэнх нь Гүүш хааныг даган Хөхнуурт очиж суусан бол үлдэсэн хошуудууд нь ойрадын чуулган дарга Очирт цэцэнд за-

хирагдаж байгаад Галдан Зүүн гарын хаант улсыг байгуулах үед Хөндлөн Увш 1663 онд нийт 3000 өрх иргэдээ дагуулан Халимагт ирсэнээр [Ианкинф (Бичурин) 1991] Ижил мөрөнд хошуудууд анх суурьшжээ. Зарим эх сурвалжид Хөндлөн Увш дүү Доржийн хамт 10000 өрхтэй Ижилд очисон гэх мэдээ бий. 1676 онд Очирт цэцэн хааны хатан Дорж-Равдан 1000 хошууд өрхийн хамт Ижилд очив. Тэрээр Халимагийн хаан Пунцагын охин бөгөөд Аюук хааны эгч юм. Хошуудууд нь XVIII зууны эхэн хүртэл Торгуудын улстай хамт байв [Авляев 2002: 147, 149, 152]. XVII зууны сүүл – XVIII зууны эхэн үед Зүүнгарт болсон дайны хөлөөс зугтан Хошууд, Хойд болон бусад аймгуудаас цөөн тоогоор Ижил мөрин лүү дайжин ирж байв [Пальмов 2007: 144].

Хошуудууд Ижил мөринд очсоныхоо дараа хүн ам болон цэрэг хүчний талаар тийм ч цөөн муу байгаагүй бололтой. Энэ ч үүднээс Ижил мөрний Халимагуудын захиргааг тэр бүр дагалгүй бие даасан байдалтай байхыг оролдох үйлдэлүүд гаргаж байв. Аюук хаан Халимагийн хаан болоод өөрийг нь эсэргүйцэгчдийг дарсан. Тухайн үед Аюукуг хамгийн ихээр эсэргүүцэж байсан хүн бол Хошуудын ван гүн Аблай тайж юм. 1661 онд Аблай, Очирт Сэцэн хаантай эвдрэлцэн тулалдаж ялагдаад, харьяат албатаа дагуулан Ижил мөрний доод урсгалд нүүдлэн мал маллаж байсан авга Хөндлөн Увшдаа ирсэн. Авлай нь Ижилд ирээд Хөндлөн Увштай хамтран Дөрвөдийн Далай тайшийн бэлчээр нутгийг довтлон, бас «торгуудын (Шүхүр) Дайчинг талж хоосруулсан байдаг». Аблайн энэхүү ажиллагаа нь Торгууд Хаант улсын бүрэн бүтэн байдалд заналхийлэх болсон тул 1672 онд Аюук, Аблайг дайлан улсыг нь эзлэн өөрийг олзлон авч жилийн өмнө өвгөн аав (Шүхүр) Дайчинаас булаан эзэлсэн нутаг бэлчээрийг эргүүлэн авав.

Халимаг дахь хошуудын ноёдын уг гарлыг хөөн үзвэл Чингис хааны дүү Хавт Хасарын 10-р үеийн Хан ноён Хонгорын хөвгүүд нь:

- Байбагасбаатар
- Түмэд Хөндлөн Дүүрэгч увш
- Номын хаан гүүш
- Засагт Чинбаатар
- Буян Хатанбаатар

- Хамгий Бэгт
 - Хайнаг Түшээт 7 болно.
- Түмэд Хөндлөн Дүүрэгч Увшын хөвгүүд нь:

- Хэлэв Далай Увш
- Увш хунтайж
- Дорж тайж
- Эрх дайчин 4 хүүтэй.

Хэлэв Далай увш нь:

- Данжин хунтайж
- Цэрэндорж
- Цог
- Луузан 4 хүүтэй.

Дорж тайж нь:

- Хай,
- Дуурирах
- Өвгөн
- Цэрэн 4 хүүтэй.

Эрх дайчин нь:

- Цагаян
- Тарва 2 хүүтэй.

Хай нь:

- Лэгбэ
- Даш
- Равдан 3 хүүтэй.

Дуурайсах нь:

- Дондог
- Цээхэй
- Маргааш
- Тарвацэрэн 4 хүүтэй.

Өвгөн нь:

- Галданжамц
- Галдандорж
- Цоломшил 3 хүүтэй.

Цэрэн нь:

- Мял гэдэг 1 хүүтэй байв.

Цагаян нь:

- Лоридамба гэх 1 хүүтэй.

Тарва нь:

- Цанж рааш
- Данжин гэх 2 хүүтэй.

Дондог нь:

- Кичиг
- Гунгаа
- Балжир гэсэн 3 хүүтэй.

Цээхэйн хөвгүүд нь:

- Тугч
- Тэх нар.

Маргаашийн хөвгүүд нь:

- Равжир
- Чин.

Тарвацэрэнгийн хөвгүүд нь:

- Увш
- Мөнгөд
- Чойжав
- Цэрбүд

Галдандоржийн хөвгүүн нь:

- Хишигжав

Лоридамбын хүү нь:

- Түгүл

Цанжраашийн хөвгүүд нь:

- Эрэмпэс
- Галданноров

Данжины хөвгүүн нь:

- Налха

Тугчийн хөвгүүн нь:

- Гэндэнноров
- Гэнгээ

Равжирын хүү нь:

- Даншир

Чингийн хүү нь:

- Харишир

Мөнгөндөөн хөвгүүд нь:

- Диваржав
- Даншлай
- Ням

Цэрбүдийн хүү нь:

- Баярлах

Байвгас баатарын дүү засагт Чинбаатар. Түүний хүү Хар савар, Хар саварын хүү Төрхөн тайж, Төрхөн тайжийн хүү Дархан тайж, Дархан тайжийн хүү Азарбаг, Азарбагийн хүү Жамъян. Жамъян нь Тэлэнгэд, Богбон 2 хүүтэй [Баатар Увш 2006: 38 тал].

1760 онд Хошуудын ноён Жамъяны хатан Дондогдаш хааны дүү Дон-Арш хатан нас барсан. Бэлэвсэн үлдэсэн Жамъян ноён нь тухайн үед Зүүнгараас нүүн ирсэн Хойдын ноён Дэжид нас барж түүний хатан Өлзий-Орших бэлэвсэн байсанд *«Надтай нийл»* хэмээн элч илгээхэд Өлзий-Орших хатан *«Таны хоёр хөвгүүн, нэг хүүхэн Дондогдаш хааны төрсөн зээ бус уу. Би энэ ганцхан өнчин хөвгүүнээ цөөн албаттай нь ганцаар орхиод тантай нийлэгч минь надад хэцүү болох болно. Зүгээр та буян санаж энэ хүүгээр минь хойд хүүгээ хийж цөөн албатай нь авч Дондогдаш хаанд анхааргаж тэд зөв гэвэл би танаас дээр юун хүн хайх бэ»* гэж хэлүүлсэнд Жамъян ноён Дондогдаш хаанаас зөвшөөрөл хүссэн бичгийг элчээр явуулсан. Дондогдаш хаан уг хэргийг зөвшөөрөн бичигт нь тамга дарж өгсөнөөр 1761 онд Жамъян ноён Түмэнжаргал хүүг 4 настай байхад нь өргөмөл хүү болгон Өлзий-Оршихийг хатнаа болгон авсан [Баатар Увш 2006: 59 тал].

Энэ хэргийн дараа тухайн үед үүссэн бусад хэргүүдийн улмаас Жамъян ноён өөрийн урьдны хатаны 2 хүү болон улсынхаа зайсангуудтай эе эвдэрсэн. Улмаар хүү Богбон нь хошууд аймгийн зайсангуудтай хамтран эцэг Жамъяны харьяатуудын ихэнхийг нь булаан авч захирах болсон. Богбоны энэхүү хэргийг Увш хаан буруутган үзээгүй. Ингэснээр Жамъян ноён, Ууган хүү Богбон болон Богбоныг дагасан Хошууд улсын зайсангуудтай зарга үүсгэн Увш хаан, Халимагийн улсын зарга, Астарханы захиргаанд хандасан боловч амжилт олоогүй. Увш хаан хэдийгээр Жамъян ноёны зээ хэдий ч түүнд туслахгүй байсан. Ийнхүү түүний хамжлага маш цөөн болсон тул нүүдлэн амьдархаа больж байшин бариулан суурин

байгуулан суух нь зөв хэмээн үзэх болов. мөн энэ үеэр Жамъян ноёны ууган хүү Тэлэнгэд цэцэг өвчнөөр нас баржээ [Баатар Увш 2006: 60 тал].

1766 онд Жамъян ноён эхнэр болон үрчлэн авсан хүү Түмэнжаргалын хамт Санкт-Петербург руу явсан [Баатар Увш 2006: 60 тал]. Тэрээр өөрийн булаагдасан хамжлагийн асуудлыг хатан хаанд тавих, энэхүү асуудал шийдэгдэхгүй бол суурин байгуулан суух зөвшөөрөл авах, суурин байгуулахад дэмжлэг үзүүлэх хүсэлтийг тавих зорилготой байв.

Санкт-Петербургт очоод Жамъян ноён эхнэр болон өргөмөл хүүгийн хамт II Екатерина хатан хаантай уулзаж, Хатан хааны зөвшөөрсөний дагуу хэсэгтээ Санкт-Петербургт амьдарсан. Жамъян ноён хамжилагаа эргүүлэн авах нь нэгэнт бүтэлгүй болсонд Вице канцлерт хандан «...*байшин бариж өгөх, хамгаалагч өгөх*»-ийг гуйсан бичиг өгсөн. Түүний хүсэлтийг хүлээн авч суурин байгуулан суухыг зөвшөөрч байшин барьж өгөхөөр болсон ба мөн 80 казак цэргийг хамгаалагчаар өгсөн. Энэхүү *хамгаалалтын 80 казак зэрэг нь хэт байгаа тул дахин нэмж 40–50 драгун цэргийг офицер, орчуулагч, бөмбөрчины хамт, нэг торх дарь, сумны хамт, усан завь, морин тэрэг, Оросоос ирсэн хүндэт зочидыг дайлах хоол хийж өгч чадах 2 сайн тогооч өгөхийг* дахин хүссэн.

Жамъян ноёны гуйсан хүсэлт бүхнийг Оросын талаас хүлээн авч байсан нь Оросын засгийн газар нүүдэлчин халимагуудыг нэг газарт суурин суулгахыг гол зорилтой болгож байсантай холбоотой.

Санкт-Петербургт байхад нь Түмэнжаргал цэцэг өвчнөөр өвдөсөнд Хатан хаанаас явуулсан 2 эмч түүнийг эмчилсэн. Жамъян ноёныг Санкт-Пётрбургаас явахад хатан хаан Түмэнжаргалд орос хэл заахыг зарлиг болгосны дагуу нутагтаа ирээд Түмэнжаргалыг Астарханы сургуульд явуулсан [Митиров 2002: 54–56]. Ийнхүү Түмэнжаргал нь тухайн үедээ өндөр боловсрол эзэмшсэн бөгөөд энэ нь сүүлд хошуудын ноён болоход нөлөөлсөн.

1770 онд Ижилийн баруун хөвөөнд Крымский Затон гэдэг газарт Жамъян ноёнд байшин барьж, суурин байгуулж өгсөн. Астарханы захирагч Н.А.Бекетов уг тосгоныг Жамъяны хот хэмээн нэрлэж байв. Уг тосгоны цаана Шамбай гэх элстэй газарт Халимагууд нүүдлэн явдаг байв.

1771 оны нүүдэл ба Хошуудыг шинээр зохион байгуулсан нь

1771 оны 1 сард Жамъяны хүү Богбонг Зүүнгараас ирсэн Дэжидийн үлдэгдэл хамжилага 1000 өрх Хойдууд, эцэг Жамъяны хамжилга хошууд болон Хатаматыг дагуулан [Лунный свет 2003: 154] Увш хааны хамт нүүсэн. Ингэснээр Ижилийн хошуудын ихэнх нь Увш хаан болон Богбоны хамт Зүүнгар луу буцсан. Хошуудын ноёдуудаас Ижилд Жаргал, Жамъян, Тэке нар үлдэсэн. Тэке нь 2 охин болон үрчлэн авсан зээ хүү Лүүрэвийн хамт амьдардаг байв.

1771 оны 10 сарын 19-нд хатан хаан II Екатерина зарлиг гарган Халимагийн засаг захиргааг устган, Халимагийн асуудлыг Астарханд хамруулан Астарханы захирагчийн (губернаторын) Канцлерийн дэргэд халимагийн асуудлыг хариуцсан Халимагийн экспедиц гэсэн хэлтэс байгуулсан [Митиров 1998: 273].

Увш хааны нүүдлээс Ижилийн баруун хөвөөн дахь Дөрвөдүүд бүгд, мөн Яндык болон Замъян (Жамъян) ноён албатуудтайгаа үлдэсэн.

Хатан хааны зарлигт «Увш хааны нүүдлийн улмаас захиргаагүй үлдсэн халимагуудыг Увш хааныг дагаж нүүгээгүй ноёдод тараан өгөх ба энэхүү үүргийг гүйцээхдээ Хатан хаанд үнэнчээр зүтгэсэн Жамъян ноёнд бусдаас илүү өрхийг хишиг болгон өгөх»-ийг Н.А. Бекетовт тушаасан [НА РК. Ф.35. Оп.1. Д.17: л. 1–4]. Жамъян ноёны албатуудын ихэнх нь Халимаг ноёдыг даган явсан [НА РК. Оп.1. Д.17: л. 338–536] ба Жамъян ноён нь Хатан хаан болон Астарханы захирагчидад Халимагийн ноёдын дотоод хэрэг болон Увш хааны нүүдлийн тухай удаа дараа мэдэгдэж байсан [Батмаев 1993: 356–357] юм.

Увш хааны нүүдлийн дараа үлдэсэн ноёдуудын хамжлагын тоог гаргуулсан бөгөөд энэ үед Хошуудын ноён Жамъян 63 өрх, Тэке 35 өрх, Лүрюп (Лүүрэв) 25 хошууд өрх, Тюмень-Джаргалан (Түмэнжаргал) хойд, зүүнгар, бурутаас бүрэлдэсэн 58 өрхтэй хэмээн мэдүүлсэн [Митиров 2002: 56]. Энэхүү ноёдын хамжлагад үлдсэн өрхүүдийг мэдүүлсэн тоо баримт харилцан адилгүй байх бөгөөд өөр нэгэн баримтад Хошуудын ноёд болох Жамъян 754, Түмэн 257, Тэке 100, Жаргал 50 өрхтэй байсан [Там же: 56] хэмээн зөрүүтэй тэмдэглэсэн байна.

Нүүлгүй үлдэсэн ноёдын хамжлагын тоог гаргуулан авсаны дараа Астарханы захирагч Н.А. Бекетов Ижилийн зүүн хөвөөнд Увш хаанаас үлдэсэн Эрхтэн, Их цоохрын улсын нийт 5007 өрхийг Жамъян, Яндык, Ф.А. Дондуков, Тэке зэрэг ноёдуудад хуваан өгсөн [Батмаев 1993: 365–366] бөгөөд ингэхдээ Хошуудын ноён Жамъянд 604 өрх өгсөн ба мөн шагнал болгон нэмж 150 өрхийг өгсөн [НА РК. Ф. 35. Оп.1. Д.17: л. 643–641]. Энэхүү хамжлагуудыг аль аль газраас өгсөн тухайд «Жамъян болон Тэке нарт Эрхтэний улсаас 60, 100 өрхийг тус бүрт нь өгсөн. Жамъянд мөн Цойжин шавь нараас (цойджин шабинер) 100 өрх, Түмэнд бага цаатанаас 100 өрх, багшийн шавь нараас 30 өрх, Зүүнгараас 110 өрх тус тус олгосон [Пальмов 1922: 115]. Жамъяны өргөмөл хүү Түмэнд Зүүнгарын 234 өрх өгсөн ба нэмэн бусад ноёдын хамжлагаас 23 торгууд өрхийг гарган хамжлага болгон өгсөн [Пальмов 1922: 115]. Өөр нэгэн мэдээнд өгүүлснээр Тэкегийн 35 өрх дээр нэмэн 65 өрх олгосон ба бусад бага ноёдууд болох Жаргал 50, Нохойн Хөвүүнд 21 өрх олгосон [Беликов 1971: 120, 124] хэмээн дурьдасан байна.

1774 онд академич П.С. Паллас Астарханы захиргаанд байх Халимагийн ноёд зайсангуудын хамжлагын бүртгэлийг гаргасан бөгөөд уг судалгааны үед Тэке 185, Түмэн 294 өрхтэй байжээ [Митиров 2002: 56].

К. Костенковын судалсанаар Жамъян 817 өрхтэй байсан ба үүний 63 нь түүний өөрийнх нь албат ба 754 нь өрх нь Увш хааны захиргаанд байж байгаад түүнд бэлгэлэгдэсэн өрх байна. Тэке 285 өрхтэй байснаас 135 нь өөрийнх нь албат, 150 өрх торгуудыг бэлгэнд ирсэн. Түмэнжаргал 315 өрхтэй байснаас 58 нь Хойдууд, 257 нь Увш хааны хамжлагууд байв. Эдгээрийг нийтэд нь баримт бичигт Хошууд улс гэж нэрлэж байсан бөгөөд нийт 1417 өрх байсны 185 нь хошууд өрх, 58 хойд өрх, 1174 нь торгууд байсан. Гэхдээ эдгээр 1174 өрхийн ихэнх нь торгуудууд байсан бөгөөд тэдний дотор эрхтэн, хэрэйд, цаатан, шавь нар байсан. Хошууд улсын дотор Теленгит (Тэлэнгэд), Урянхас нар байв [Митиров 1998: 319].

Нэгэн цагт төрсөн хүүдээ ихэнх хамжлагаа алдан суурин амьдралыг сонгож байсан хошуудын Жамъян ноён Увш хааны нүүдлийн дараа дахин олон тооны хамжлагатай болж чадсан юм. Тэрээр 1771 онд Астарханы захирагч Н.А.Бекетоваас Увш хааны

байсан Коровья Лукад байх цэцэрлэгийг гуйн авч уг газар шинээр суурьших болсоноор урьдын сууж байсан Жамъян хот байсан газар нь Казак станиц байгуулагдсан.

Оросоос халимагуудыг дахин зөвхөн өөрсдөөр нь засаг захиргааны шинэ хувиар байгуулан дээд эрхийг нь Астарханд захируулж дотоод аймаг улс зэрэг захиргааг нь Халимаг ноёдоор захируулсан ч гэсэн алсдаа тэднийг удирдлагаас бүрэн шахан гаргахыг хүсэж байв.

Энэ ч үүднээс Хошуудын ноён Жамъян нас барсанаар Хошууд улсын угсаа залгамжилалын асуудалд хэцүү болсон. Яагаад гэвэл улсын ноён болох хүн Жамъянгийн өргөмөл хүү Түмэнжаргал нь Хойд гаралтай байсанд оршино. Торгууд хаант улсыг Дондог-Даш хаан толгойлох цагт Ижил руу Хойдын Дэжид ноён 800 өрхийн хамт нүүн ирсэн. Дэжид нас барсаны дараа түүний хатан Өлзий-Орших (Ельзе-Ороших) хошуудын Жамъян ноёны хатан болсон. Дэжид ноёны Тюмень хотод төрсөн Түмэн жаргал хүүг нь Жамъян ноён үрчлэн авсан. Жамъян ноён нь урьд Дондог-Даш хааны эгч Дон Аршийг хатан болгон авсан байсан бөгөөд Дон-Арш хатанаас гарсан 2 хүүдээ Жамъян ноён өв хөрөнгөө өгөлгүй үрчлэн авсан Түмэн жаргалд өгсөн [Пальмов 2007: 142] ба эцэгтэйгээ эе эвдэрсэн Жамъян ноёны Дон-Арш хатны хүүхдүүд нь эцгийн хамжлагын ихэнхийг аван Увш хааны хамт нүүсэн билээ. Ингэснээр Жамъяныг түүний өргөмөл хүү Түмэнжаргалаас өөр залгамжлах хүн байхгүй болжээ. Хошууд улсын захирагчийн хувьд бол Хойд гаралтай урьдын ноёны өргөмөл хүү Түмэнжаргалаас гадна Жамъяны нэгэн адил Увш хаантай хамт нүүлгүй үлдэж Оросын хатан хаанаас хишиг хүртэсэн Тэке зэрэг хошууд ноёдууд хошууд улсын захирагч болох бололцоотой байв.

Энэ үед Астарханы захирагч Н.А.Бекетов «энэ цаг бол Халимагуудыг тэдний ноёдоос нь шууд булаан авах тохиромжтой цаг ирсэн» гэж Оросын Гадаад хэргийн яаманд мэдээлсэн. 1774 оны 4-р сарын 30-нд Н.А. Бекетовын дараа Астарханы захирагч болсон Кречетниковд нэгэн хариу ирсэн нь «Яньдик (Яндык), Жамъян ноёноос үлдэсэн улсуудыг захирах сайн арга олохыг» хүссэн [Костенков 1870: 36] байдаг.

Энэхүү эгзэгтэй үед Хошуудын улсыг хэсэгтээ Өлзий-Орших хатан захирсан ба дараа нь Түмэнжаргал Хошуудын ноён болоод өөрөө хойд хүн тул цөөхөн хойдыг давхар толгойлох [Небольсин 1857: 11] болжээ. Тэке нас барсаны дараа түүний зээ хүү Лүүрэв улсыг нь авсан.

Энэхүү Хошууд улсыг хэн захирах тухай маргаан 100 орчим жил үргэжилсэн ба Жамъян ноён Түмэнжаргалыг үрчилэн авсан учираас Түмнийхэн Хошуудыг захирах нь зөв хэмээн шийдсэн [Митиров 1998: 319]. Түмний угсааныхан өөрсдөө боловсрол өндөртөй, Астарханы захиргааныхантай сайн харилцаатай байснаа ашиглан элгэн садан (Тэке, түүний 2 охин, Жаргал, Цагалай) нарыгаа нас барсаны дараа бүх албатыг нь өөртөө нэгтгэн авч хүчирхэгжиж байв. Түмнийхэний ноёдын залгамжлалыг авч үзвэл Дэжидийн Түмэнжаргал нь:

- Сэр-Оджав
- Баатар увш
- Цэрэндондог
- Цэрэнноров гэсэн 4 хүүтэй.

Сэр-Оджавын хүү нь:

- Гэсэржав

Баатар Увшийн хүү нь:

- Цэрэн Увш

Цэрэндондогийн хөвгүүд нь

- Цэрэнжав
- Цэрэндорж

Цэрэнжавын хөвгүүд нь:

- Цэрэннадмид
- Цэрэнчимэд

Цэрэндоржийн хөвгүүд нь:

- Константин

Цэрэнноровын хөвгүүд нь:

- Бат хиа

- Баатар хиа нар аж [Баатар Увш 2006: 39 тал].

Мөн Түмэний угсааны хошууд ноёдууд нь дайн тулалдаанд баатар гавъяа байгуулан нэрд гарч байв. Түмэнжаргал сургууль сурч, цэрэгт явж, дайнд орох зэрэгтээ бусдаасаа ялгаран гавъяа

байгуулан амжилт гаргаж удаа дараа шагнагдаж байв. Тэрээр Емельяна Пугачевын бослогыг дараад цэргээс ерөнхий хошууч (премьер-майор) цолтой буусан. Тэр 4 хүүтэй хэд хэдэн охинтой байв. Хөвгүүд нь сайн боловсрол эзэмшиж өөрийн улсын түүхэнд их нэрээ үлдээсэн. Тэдний нэг нь Сэрэбжаб Түмэн (Серебджаб Тюмень). Сэрэбжаб Түмэн Кавказад цэргийн алба хаахдаа 500 халимагийг толгойлж, амжилт гаргасан тул ахмад цол авсан. 1812 оны эх орны дайнд оролцон Городечно гэдэг газар амжилттай тулалдасан тул 7-р сарын 31-нд Алтан илдээр (золотая сабля «За храбрость») шагнуулсан. 1913 оны 12-р сард, 1814 оны 2-р сарын тулалдаануудад баатарлаг гавъяа байгуулсан тул Ариун Аннын 2-р одонгоор шагнагдсан. Хилийн чанд дахь тулалдаанд онцгой гавъяа байгуулсан тул Владимирын 4-р одон, ариун Георгийн 4-р одонгоор шагнагдсан. 1814 оны 3-р сард дэд хурандаа цолтой болсон. 1816 оны 7-р сард Пруссийн хаан түүнд Улаан бүргэдийн (Красного Орла) 2-р одон өгсөн. (Энэ нь 1792 оноос Пруссийн хаант улсын 2-р зэргийн одон юм.) Удалгүй энэ одонг Пур-ле-Мерит одонгоор солисон (энэ нь дэлхийн 1-р дайн хүртэл Пруссийн цэргийн хамгийн өндөр одон байсан). Дайн дууссаны дараа Сэрэбжаб Түмэн халимаг улсын засаг, Улсын Заргад ажиллаж, Хошуудуудыг захирч байв. Тэр удаан хугацаанд цэрэгт алба хаасан бөгөөд хурандаа цолтой байв. Тэр Хошуудуудыг захирч байхдаа шинэ газар худалдан авах, загас барих газар, барьсан байшин худалдан авах, цэцэрлэг байгуулах, малын үйлдвэр сайжируулах зэрэг шинэлэг ажлуудыг хийж байв [Митиров 2002: 241, 244].

Хошуудын ноён Жамъян орос хэлний чухал хэрэгцээг мэдрэн хатан хааны зарлигийн дагуу өөрийн хүүгээ Астарханы Орос сургуульд сургасан. Түмэнжаргал ч гэсэн хожим өөрийн хөвгүүдээ оросын өндөр боловсрол олгосон юм. 1797 онд Польшийн аялагч Я. Потоцкий Астархан хотод Цэрэбжаб Түмэнтэй орос хэлээр чөлөөтөй ярин ойлголцож байсан тухайгаа бичин үлдээсэн байдаг.

Түүний дүү Баатар Увш Түмэн бас зоригтой дайчин, зохиолч, орчуулагч, түүхч байсан. Тэрээр «Дөрвөн ойрадын түүх» номыг бичсэн. Мөн архитекторч байсан. Тэрээр Чемби гэлэнтэй хамт Хошуудын хурлыг 1812 оны эх орны дайны ялалтад зориулан босгон. 1831 онд Орос Польшын дайны үед Остроленка гэдэг хотын дэргэд нас барсан [Лунный свет 2003: 159].

XIX-р зууны дунд үед Хошуудын улсд 2000 өрх байсан. Тэднээс 400 хошууд, 800 орчим торгууд 1771 оноос хойш Жамъянд өгсөн (хэрэйд, эрхтэн, цаатан), 150 тэлэнгид, хойд, урианхас байв. Цөөхөн хахачин, мэргэчүүд, хангууд, чигээч нар байв. Эднээс гадна Хурлын шавь нар гэж байв [Митиров 2002: 56–59]. Францын зохиолч А. Дюма бичсэнээр Түмэний албат нар 11000 [Дюма 1993: 291] гэсэн байдаг.

Хошууд улс өвөлжин болон зуслан гэсэн 2 газраар нүүдэг байсан. Өвөлжөөний өргөө нь Тюмених (Тюменевка) гэдэг тосгонд байсан. Түүний дэргэд хошуудын хурал (Хошуудын сүм)-ыг байгуулсан. Зуслан нь Ижил, Ахтуб хоёр голын цаанаа Ашулук гэдэг голын зүүн хөвөөнд Ордлигийн цэке (Ордлигин-цеке) гэдэг газарт байв. Зүүн талаас Хасагууд (Внутренне-Киргизская-Орда) болон Кундровскийн татартай, бусад талаараа Оросын тосгонуудтай хиллэж байв. Өвөлжин нь Ижлийн баруун хөвөөнд байж, Инэтавскаас (Енотаевка) Журуковский станиц хүртэл үргэжилж байв. Тэдний нутаг Ижлээс цааш 70 верст үргэжилж байжээ [Небольсин 1857: 23, 25].

XIX зуунд Хошууд улсын нүүдэл Ижил голын 2 хөвөөгөөр байсан 1771 оноос улсын бүрэлдэхүүн их өөрчилөгдөсөн. Тэр цагаас авна Их цоохорын улсын Хошууд аймаг Сарпа нуурын хөвөөнд нутаглах болжээ [Авляев 2002: 154].

Их цоохорын хошуудын зайсан Н.Натыровын албатнууд дараах газруудаар нүүдлэж байв. Андран гашун худг, Кавшан худг, Мукөвүна худг, Анюша худг, Өмн кайрүлч, Дунд кайрүлч, Ар кайрүлч, Өмнө кивзн, Аршин худг, Дунд кивзн, Ар кивзн, Чагля, Ээвайн цаца, Луузра, Долан худг, Ацан худг, Бор хөвүнай царн, Цаган толхай, Анжхан хаг, Газад дала, Найрн шар, Жирн сөг, Тавн толхай, Нохан толхай, Шар царн, Шар тээг, Товхн толхай, Алахан бор, Хавтха толхай, Шовхр толхай, Халтрин бор, Цаган усна царн, Керүлчин хар толхай, Хазг, Хар халзн, Мөст, Хурла хуучн үвлзн, Харахна үвлзн, Хазг хулсн, Шовуна арл, Сенай, Шүптр, Доржин Лижин үвлзн, Батнасна кошар, Канав, Итлгин бөөрг, Жирглтин бөрг, Манжин худг, Нимгня көвя, Жүгя, Миихлдг гэсэн газраар нүүдэг байсан [Шантаев: 20].

Хошууд улс нь олон овогуудаас бүрэлдэж байсан. Тухайлвал 1771 онд Увш хааны нүүдлийн дараа хошуудын Жамьян ноёны

Астарханы захирагч Н.А. Бекетовд хүсэлт гаргасны дагуу олгосон 754 өрх ба сүүлд дахин нэмж олгосон 257 өрхийн ихэнх нь торгуудууд голдуу байсан ба торгуудын хэрэйд, эрхтэн зэрэг овогууд байв. Хошууд нь дотороо Их-хошууд, Бага-хошууд, шинээр үүссэн Хатамыш, Цагалай буюу цэвэр хошууд зэрэг хэд хэдэн хэсэгт хуваагдаж байв. Тэд өөрсдийгөө Чингис хааны хишигтэн цэргээс гаралтай гэж үздэг байв. П. И. Небольсины үзсэнээр хошуудын улсын дотор дөрвөдүүд байх бөгөөд тэд урьд нь мэргэн анчин байсан Уранхус (Урианхай) ястай байна. Хошуудын дөрвөдүүд Уранхус (Урианхай), Девлют (дэвэлт) 2 овогт хуваагдана. Хошуудын улсад Хойд, Хахчин байна. Хошууд улсын Шавьнар өөрсдийгөө торгууд эрхтэн ба их хошууд гэж нэрлэдэг байсан. Тэдний дунд нэг онцгой овог байсан нь тэр овог нь Хазлай шавь нар, Чойжиг шавь нар гэсэн хоёр овогт хуваагдана. Хошууд улсын Шавь нар, Мэргэчүүд, Цаатан, Чигээч гэсэн 4 овогийн уг гарал нь тодорхой мэдэгдэхгүй байна [Небольсин 1857: 17–19] хэмээн тэмдэглэсэн байна.

XIX зууны сүүлээс одоо үе

1. XVIII зууны дунд үе гэхэд Хошуудын улс нь дотороо 19 овог 19 аймаг, улсад хуваагдаж байсан бөгөөд эдгээр аймгуудаас хамгийн хүчирхэг нөлөөтөй нь Түмнийхэний улс байв [НА РК. Р–131. Оп. 1. Д. 500]. Энэ ч учраас зарим баримтад нийтэд нь Хошуудын улсыг Түмнийхэний улс хэмээн тэмдэглэх нь байдаг. Энэ үед Оросын III Александр хаан Өмнөд нутгаараа явахдаа Халимаг төдийгүй, тухайн бүс нутагтаа нэр нөлөө бүхий Тюмений (Түмний) улсад ирэхэд, тэдний ноёдууд нь хүндэтгэн хүлээн авсан байдаг. Энэ үеэс эхлэн Хошуудын улсыг Александрын (Александровск) улс гэж албан бичгүүдэд тэмдэглэх болов. Тухайн үед Хошуудын улс нь хүчирхэгжин бусад овог, аймгуудыг өөртөө нэгтгэн захирах нь их болжээ. Тухайлбал энэ үеэс Зүүнгар, Торгуудуудын зарим хэсэг нь нутагладаг Багацоохорын улсыг өөртөө нэгтгэснээс Багацоохорын улсыг Александровско-Багацохуровский улус хэмээн нэрлэх болов.

Тухайн үед халимагийг Александровский, Малодербетовский, Большедербетовский гэсэн гурван улсын ноёдууд ерөнхийд нь захирч байсан. 1892 оны 3 сарын 16 өдрийн засгийн шинэчлэлээр

аймгийн ноёд зайсангуудын эрх мэдлийг хязгаарласан юм. 1896 онд Александрын улсад 2053 өрх, 4484 эрэгтэй, 4459 эмэгтэй хүнтэй байсан [КИГИ РАН. Ф. 1. Оп. 1. Ед. хр. 694]. Яндыкийн ноёдууд Каспийн тэнгис орчимын загасчин Мочажийн иргэдийг өөрсдөө нэгтгэн Яндыко-Мочажийн улс гэх болсон. Малодербетовский улс нь хэт урт сунаж тогтосон байсан нь удирдлагад муугаар нөлөөлөж байсан тул хоёр хуваан Хойд хэсгийг нь Малые Дербеты, өмнөд хэсгийг нь Маныч улс хэмээн нэрлэх болсон. Ингэснээр Халимагт 1907 оноос 1913 хүртэл Эркетене улс, Яндыко-Мочажийн улс, Хошуудын (Александрын) улс, Багацоохорын улс, Ики цоохорын улс, Малодербетовский улс, Манычский улс, Большедербетовский улс гэсэн 8 улс, 198 аймаг, 772 хотонд хуваагдаж байлаа. 1909 онд дахин шинэчлэл хийн 198 жижиг аймгийг нэгтгэн 34 аймагт шинээр хуваасан. Эдгээр нь

Манычийн улс:

1) Оргакин аймаг. Ахлагч нь Эрдени Бадмаев, 28 настай, шашны сургуулийн 4 анги төгссөн. Дунд зэргийн малтай.

2) Ульдүчин аймаг. Ахлагч нь Санджи (Кура) Леджинович Сумьянов. Зайсан. 47 настай, хүмүүст их таалагддаг, дунд зэргийн малтай.

3) Яшкуль аймаг. Ахлагч нь. Больдюр Бельтриков. 30 настай. Сайн орчуулагч, улсын заргад ажилдаг.

4) Бурул аймаг. Ахлагч нь Музра Лиджинов (өөр нэр нь Цаганов). 41 настай, дунд зэргийн малтай, олон жил энэ ажлыг хийж байгаа.

5) Бага-Чонос аймаг. Ахлагч нь Цебек Дюсембеев. 48 настай. Олон жил ажиллаж байгаа.

6) Ики-Чонос аймаг. Ахлагч нь Мальжи Мацаков. 57 настай. Дунд зэргийн малтай.

Эркетеневский улус:

7) Багацаатан аймаг. Дорджи Болдырев. 47 настай.

8) Овордык аймаг. Ахлагч нь Буча Бульдаков, 44 настай. Адуу үржүүлдэг, олон жил улсын заргад төлөөлөгчөөр ажиллаж байгаа, бичиг үсэгтэй.

9) Кеке-Усун аймаг. Ахлагч нь Манджи (Чимид) Хадбитов, 51 настай. Адуучин малчин, бичиг үсэгтэй, олон жил сонгогдсон.

10) Гайдук аймаг. Ахлагч нь Гаря Даланов, 63 настай. Адуучин малчин, бичиг үсэгтэй, хүмүүсийн дунд маш их нөлөөтөй.

Икицохуровский улус:

11) Ачинер-Эркетен аймаг. Ахлагч нь Цаган-Убуши Леджинов. 48 настай. Зайсан. Адуу бод мал өсгөдөг. Бичиг үсэггүй, маш их нэр хүндтэй.

12) Сатхало-Хошеут аймаг. Ахлагч нь Догур Борнаев, 42 настай. Адуучин, сайн орчуулагч, улсын захиргаанд ажилдаг.

13) Кетченер-Шебенер аймаг. Ахлагч нь Яшкуль Манджиев. 25 настай. Сайн орчуулагч улсын захиргаанд ажилдаг.

14) Зюнгар аймаг. Ахлагч нь Менко-Насун Джоджиев, 41 настай. Зайсан. Бод мал өсгөдөг.

Харахусовский улус:

15) Харахус аймаг. Ахлагч нь Сангаджи Очир-Гаряев. 49 настай. Худалдаачин, бичиг үсэгтэй, нөлөө ихтэй архи уудаггүй, олон жил сонгогдож байгаа.

16) Эрдниев аймаг. Ахлагч нь Кока Зодбаев. 60 настай. Малчин. Бичиг үсэгтэй. 20 дээш жил сонгогдож байгаа.

Александровский улус:

17) Сереб-Джапов аймаг. Ахлагч нь Убуши-Церен Убушаев. 33 настай. Бичиг үсэгтэй, сонгогдон ажиллаж байсан, малчин.

18) Тюмене аймаг. Ахлагч нь Босхомджи Балдрунов. 41 настай. Бичиг үсэгтэй, малчин, олон жил сонгогдож ажиллаж байгаа.

Яндыко-Мочажный улус:

19) Ики-Багут аймаг. Ахлагч нь Очир-Гаря Менко-Убушевич Габун-Джамбаев. 36 настай. Зайсан. Худалдаачин, малчин. Гимназийн 3 анги төгссөн.

20) Багут аймаг. Ахлагч нь Бабгуш Дензенов. 50 настай. Худалдаачин малчин. Маш их нөлөөтөй, олон жил сонгогдон ажиллаж байгаа.

21) Харахус аймаг (Мочажийн захиргаа). Очир Лозунгов. 40 настай.

22) Далбан аймаг. Инджир Санджиев. 45 настай. Орчуулагч, улсын захиргаанд ажилдаг, архи уудаггүй. Чухал хэрэгт нямбай, тамга шалгагч.

23) Баатут аймаг. Ахлагч нь Урубджюр Эрдениев. 40 настай. Зайсан.

24) Багацоохор аймаг. Ахлагч нь Убуши Хара-Манджиев. 60 настай. Худалдаачин, нямбай хүмүүсийн дунд нөлөө ихтэй, бичиг үсэггүй.

Малодербетовский улус:

25) Северный аймаг. Ахлагч нь Батак Ванькаев. 53 настай. Малчин, бичиг үсэг сайн, нөлөө ихтэй.

26) Приволж аймаг. Ахлагч нь. Дава Зурманов. 27 настай. Сайн орчуулагч, улсын сургуулийн багш.

27) Шебенер аймаг. Ахлагч нь Батыр Перлеев. 34 настай. Орчуулагч. Улсын захиргаанд ажилдаг.

28) Абганер аймаг. Ахлагч нь Семен Эренценов. 33 настай. Дунд сургуулийн багш, багшийн семнар төгөссөн. Сонгогдон ажиллаж байгаа.

29) Сальск аймаг. Ахлагч нь Дорджи Санджиев-Баваев. 32 настай. Зайсан. Адуу бод мал өсгөдөг, газар хэмжигч, бичиг үсэгтэй.

30) Шарнут аймаг. Ахлагч нь Барва Тегусов. 49 настай. Зайсан. Малчин. Бичиг үсэгтэй.

31) Центральный аймаг. Ахлагч нь Тарас Мучкаев. 32 настай. Сайн орчуулагч, улсын заргад ажилдаг.

32) Цагаан-Нуур аймаг. Ахлагч нь Санджи Лиджиев Талтаев. 58 настай. Бичиг үсэгтэй, адуу болон бод мал өсгөдөг. Үе залгамжилсан тайж угсаатай зайсан.

Багацохуровский улус:

33) Барун аймаг.

34) Зюнгар аймаг.

Энэхүү 1909 оны засаг захиргааны шинэчлэлээр Хошуудуудын ихэнх нь нутаглаж байсан нутгаараа Их цоохорын улсын Сатхал-Хошеут аймаг болсон бөгөөд уг аймгийн ахлагч Догур Борнаев 42 настай, Улсын захиргаанд ажилдаг, сайн орчуулагч, адуу өсгөдөг хүн байсан.

Хуучны Хошуудын улс буюу Александрын улс нь Сереб-Джаб, Тюмень гэсэн 2 аймагт хуваагдсан.

1907–1909 онд хуралдасан Хаант оросын 2-р Думд Серебджап Батыкович Тюмень халимагуудаас төлөөлөн сонгогдож байв.

Ингэснээр хүн амь цөөн, нүүдлэн амьдардаг Хошуудууд дахин хуваагдсан байна.

XX зууны эхээр Хошууд улсад дараах овог, өрхүүдээс бүрэлдэж байв. Кирлянкин 40 өрх, бага эрхтэний 48 өрх, цаатаны 377, ики хошуудын 81, бага хошуудын 92, мэргэчүүдийн 40, шавьнарын 91, хойт хахачинерын 97, бага-керетын 32, керет 299, урянхус 91, их ба бага теленгитын 82, цагланкины 68, эркетены 106, убушанкины 82, доглмут 62, чиячинер 26 өрх байсан [Митиров 2002: 62]. Их цоохорын улсад хошууд Ниме Натыров зайсангийн албат нар [КИГИ РАН. Ф. 1. Оп. 1. Ед. хр. 694] болох 386 өрх хошууд байв [Митиров 2002: 60].

1920 оны 11 сарын 21-нд Харахусо-Ики Цоохорын улсын хошуудуудын анхны сургууль 60 сурагчтайгаар нээгджээ.

1928 онд анх Их цоохорын улсын Хошууд аймагт «Хоничин» («Овцевод») нэртэй сангийн аж ахуй байгуулагдсан. Энэхүү сангийн аж ахуйг «Сарпа 10» хэмээн нэрлэдэг байсан бөгөөд Халимагт хамгийн анхны, Зөвлөлт Оросод 10 дахь сангийн аж ахуйн болж байгуулагдсан учир ийнхүү нэрлэдэг байсан аж. Тухайн үед Хошуудууд нь Сарпа нуурын хөвөөгөөр амьдарч байсан тэднийг одоо Сарпан хошууд гэх нь элбэг байна. 1929 оноос сангийн аж ахуйн төв дээр 7 орон сууц, аж ахуйн байр, дэлгүүр, баян зэргийг байгуулсан нь одоогийн Сарпа тосгоны суурь болсон. Анхны сангийн аж ахуй нь 9272 мал 100 ажилчинтай [Буваев, Джавкаев, Очирова, Белоусов и др. 2008: 57] байв.

Сарпан Хошуудуудын дунд мал олонтой сайн малчин хүмүүс олон байсан бөгөөд 1920-иод оны сүүлээр болсон чинээлэг малчин хөрөнгөтнүүдийг хавчих хөдөлгөөн тэднийг тойроогүй. Сарпагаас Балдра Басанга Анка, Көткөр Очра Манж гэсэн хүмүүсийг энэ үеэр мал ихтэй хөрөнгөтөн хэмээн Башкир руу цөллөгөнд явуулсан бөгөөд тэд цөллөгнөөс буцаж ирээд дахин 1943 онд Сибирь руу цөллөгдөсөн байдаг.

1939 онд Халимагийн Хошуудын улсын 53 газарт нийт 2491 хүн амьдарч байв [НА РК. Р-131. Оп. 1. Д. 500].

1941 онд Эх орны дайн эхлэхэд Сарпан хошуудуудаас 317 хүн цэрэгт татагдасан ба тэдний 102 нь амьд эргэж ирсэн.

1943 онд Хошуудууд нь нийт халимагуудын хамт Сибирьт цөллөгдөсөн. 1957 онд цөллөгнөөс Халимагуудыг чөлөөлөхөд Хошуудууд эргэн Сарпа тосгондоо ирж суурьшсан. Энэ үед Ижил мөрний цаад талд байсан хуучин Хошууд улсын газар нутгийг Халимагуудад өгөлгүй Астарханы захиргаанд үлдээсэн учир тэрхүү газар нутаглаж байсан Хошуудууд Сарпан хошуудууд болон халимагийн бусад газруудад ирж суурьшив.

1961 онд Сарпан сангийн аж ахуйгаас машин техникийн аж ахуйнуудыг нь салган шинээр Хошут тосгон болгон тусгаарлаж техникийн бааз, Сарпаг мал аж ахуй, тариалангийн тосгон болгон зохион байгуулсан. 1963 онд засаг захиргааны шинэчлэсэн зохион байгуулалт хийхэд Кетченер (Кетчеровский) районоос хошуудуудын амьдардаг дээрхи хоёр тосгоныг салгаж, Хошууд тосгоныг Октябрь (Октябрьский) районд, Сарпа тосгон нь Юстин районд харьяалуулахаар болсон. 1992 оны 2 сард Сарпаг дахин Кетчеровский районд харьяалагдах болсон бол Хошууд нь Октябрьский райондоо үлдэсэн.

Сарпа тосгон нь одоо Кетченер районд харьяалагдаж Элиста хотоос 226 км, Кетченер районы төвөөс 110 км-ын зайд оршино. Тус тосгон нь 729 хүн амтай, 167000 га газар нутагтай ба Чкалов, Алцын-Хутин, Чилгир, Привольнен, Юстин, Хошеут зэрэг тосгонуудтай хиллэх ба Шорв, Алтн булг, Шорвин кец гэсэн 3 фермтэй.

2008 онд Сарпа нь бүх Оросын аж ахуйн «алтан намар» үзэсгэлэнгээр тэргүүн байранд шалгарч байв. 2009 онд 22,9 сая рублийн орлого олж улсад 8,2 сая рублийн татвар төлсөн бол 2010 онд ойролцоогоор 10 сая рублийн татвар төлжээ. 2010 онд 444,5 тонн мах бэлтгэн худалдаалсан [Хальмг үнн: 10].

Сүүлийн 20 жилд болсон эдийн засгийн доройтол, шилжих хөдөлгөөний улмаас Ихцоохорын хошуудуудын амьдарч байсан Керкан, Шоринг, Алтан булагт зэрэг тосгонуудад огт хүн амьдрахгүй болсоноор татан буугдав.

Одоо хошуудууд нь Кетченер районы Сарпа, Алцынхута тосгон болон Октябрьск районы Хошут тосгон, Юстинский районы бусад тосгонуудад цөөн тоогоор тархан амьдарч байна.

Халимагуудын нэгэн хуучин уламжлалаа хадгалан үлдэж чадсан нь овог дотороо арванаа хадгалан одоо хүртэл хэрэгсээр байгаа явдал юм. Одоо Сарпан хошуудын дотор Шарад, Көткр, Луузн, Сагсг, Чонахн, Мельшайхн, Бадмин Харахн, Дашихн, Кавшахн, Монголмууд гэсэн 10 арван байна.

Хошууд аймгийн магтаал

Чингис богд унштай
Чимилхайтай Жангар түүхтэй
Заяа бандид багштай
Хошууд аймаг
Эргнай ширийн зэргээс
Эрднин Хархус хөвөөлөөд
Арын шорвон хулснаас
Адарга дагаж жирийсэн
Амны билгээр хэлэгдсэн
Алтан булаг нутагтай
Халимаг газрын хэвлийд
Хошууд аймгаараа бүүрэлсэн.

Халимагийн хошуудууд Зүүнгарын хаант улс байгуулагдах үеийн улс төрийн зөрчилийн улмаас 1663 онд Хөндлөн Увшийг даган анх очисон ба дараа нь Аблай тайш, Дорж Равдан хатан, Дэжид ноён нар өөрийн албат хошуудуудаа дагуулан очсоноор бүрдэсэн байна. Хөндлөн Увш, Дорж, Аблай нарын дагуулаж очсон хошуудууд эхэндээ бие даасан цэрэг сайтай байж Ижилд байсан бусад Дөрвөд, Торгуудуудын эзэмшилд халдаж байсныг Аюук хаан цэргийн хүчээр номхотгон Халимаг хаант улсынхаа бүрэлдэхүүнд оруулсан юм. Улмаар 1771 онд Халимагууд Зүүнгар луу буцах үед ихэнх хошуудууд Увш хааныг даган нүүсэн. Нүүдлийн дараа үлдэсэн Жамъян ноёны хошуудууд дээр бусад нүүсэн язгууртнуудын үлдэгдэл өрхүүдийг хишиг болгон өгсөнөөр хошуудууд нь дахин хүн ам болонтой болж хүчирхэгжиж эхэлсэн. Жамъян ноёны дараа түүний өргөмөл хүү хойд Түмэнжаргал хошуудуудыг захирах болсон бөгөөд Түмэнжаргалын угсааныхан хошуудуудыг захирч байсан XIX зууны үед хошуудууд хөгжлийн оргилдоо хүрч халимагийн удирдах ноёлох аймаг болж чадсан. Түмэнжаргалын угсааныхан ч өөрсдөө европын боловсрол эзэмшсэн. Цэрэг дайны

авъяаслаг удирдагчид байснаараа түүхэнд үлдэсэн. Тэдний үед Оросын Александар хаант хошуудад зочлож, хошуудын сүм болон дөрвөн ойрадын түүх зэрэг түүх соёлын хосгүй бүтээлүүд үйлдэгдэж тэдний цэрэг дайны алдар мандан бадарч байлаа.

XX зуунд Зөвлөлт Оросод болсон хувьсгалын нөлөө болон 1920 оны өлсөглөн, 1930 оны шашны хэлмэгдүүлэлт, 1943 оны цөллөг зэргээс болоод хүчирхэг байсан Хошууд улс бутран тараж, газар нутагаа алдасан юм. Одоо Халимагт байгаа Хошуудууд нь хошууд улсын шууд залгамж нь биш ч гэсэн XIX зууны дунд үед Ихцоохорын улсад байсан цөөн тооны халимагуудын цөм бөгөөд тэдэн дээр XX зуунд бутран тарсан хошууд улсын өрхүүд нэмэгдэснээр үүссэн байна. Сарпан хошуудуудаас гадна урьданы хошууд улсын газар нутаг дээр орос болон торгууд, дөрвөдийн дунд хошуудууд нэгдмэл биш тарсан байдалтай байсаар байна.

Ашигласан материал

НА КалмНЦ РАН. Ф. 1. Оп.1. Ед. хр. 694.

НА РК. Ф. 35. Оп.1. Д. 17. л. 1–4.98.

НА РК. Р-131. Оп.1. Д. 500.

Sources

Kalmyk Scientific Center (RAS), Scientific Archive. Coll. 1. Cat. 1. Item 694. (In Russ.)

National Archive of the Republic of Kalmykia. Coll. 35. Cat. 1. File 17. Pp. 1–4, 98. (In Russ.)

National Archive of the Republic of Kalmykia. Coll. Р-131. Cat. 1. File 500. (In Russ.)

Судалгааны бүтээл

Авляев Г.О. Происхождение калмыцкого народа. 2-е изд. перераб. и исправл. Элиста: Калм. кн. изд-во, 2002. 325 с.

Авляев Г.О., Санчилов В.П. К вопросу о происхождении торгоутов и хошоутов в этническом составе средневековых ойратов Джунгарии. (К проблеме этногенеза калмыков) // Проблемы этногенеза калмыков. Элиста, 1984. С. 43–58.

Баатар Увш. Дөрвөн ойрадын түүх оршив. BIBLIOTHECA OIRATICA–II. Латин галиг, үгийн цэс үйлдэж кирилл бичгээр хөрвүүлэн удиртгал, тайлбар бичсэн Б. Түвшинтөгс, На. Сүхбаатар. УБ., 2006. 180 с.

Батмаев М. М. Калмыки в XVII–XVIII веках. События, люди, быт. Элиста: Калм. кн. изд-во, 1993. 381 с.

Беликов Т.И. Участие калмыков в крестьянской войне под руководством Е.И. Пугачева (1773–1775). Элиста: Калм. кн. изд-во. 1971. 167 с.

Буваев Л.Б., Джавкаев С.С., Очирова Н.Г., Белоусов С.С. и др. Дорогие мои Кетченеры. (Юбилейное издание). Элиста, 2008. 180 с.

Генеалогия Икицохуровских хошутов (по материалам, собранным Ш.В.Боктаевым). Сост. Б.Б.Манджиева. Элиста: КИГИ РАН, 2011. 326 с. Серия «Өвкнрин зөөр» (Сокровища предков). На рус. и калм. яз.

Дюма А. Путевые впечатления в России. Т. 3. М.: Науч.-изд. центр «Ладомир». 638,[1] с., [24] л. ил.

Ианкинф (Бичурин Н.Я.). Историческое обозрение ойратов или калмыков с XV столетия до настоящего времени. Элиста: Калм. кн. изд-во, 1991. 128 с.

Костенков К.И. Исторические и статистические сведения о калмыках, кочующих в Астраханской губернии : С картою Калмыцкой степи / Сост. Главный Попечитель Калмыцкого народа генерал-майор К. Костенков. СПб.: Министерство Государственных Имуществ; хромолит. Н. Глыбова, 1870. 170 с. 1 л. карт.

Лунный свет: Калмыцкие историко-литературные памятники. Пер. с калм. / Сост., ред., вступ. ст., предисл., коммент. А. В. Бадмаева. Элиста. Калм. кн. изд-во, 2003. 477 с.: ил.

Митиров А.Г. Ойраты-калмыки: века и поколения. Элиста: Калм. кн.изд-во, 1998. 384 с.: ил.

Митиров А.Г. Истоки. Элиста: Калм.кн.изд-во, 2002. 272 с.

Небольсин П. Очерки быта калмыков хошоутовского улуса. СПб.: тип. К. Крайя, 1852. 192 с., 2 л. ил., карт.

Пальмов Н.Н. Материалы по истории калмыцкого народа за период пребывания в пределах России. Элиста: Калм.кн.изд-во, 2007. 464 с.

Пальмов Н.Н. Очерки истории калмыцкого народа за время его пребывания в пределах России. Астрахань: Калм. гос. изд-во. 1922. 137 с.

Санчиров В.П. Этнический состав ойратов XV–XVIII вв. По данным «Илтэхэл шаштир»// Из истории докапиталистических отношений в Калмыкии. Элиста, 1977. С. 11-18.

Хальмг үнн. 25 ноября 2010 г. №216–217. С. 10.

Шантаев Б.А. Из истории калмыков-хошутов // Генеалогия Икицохуровских хошутов (по материалам, собранным Ш.В. Боктаевым). Сост. Б. Б. Манджиева. Элиста: КИГИ РАН, 2011. 326 с. Серия «Өвкнрин зөөр» (Сокровища предков). На рус. и калм. яз.

References

Avlyayev G. O. Origins of the Kalmyk People. 2nd ed., rev. and suppl. Elista: Kalmykia Book Publ., 2002. 325 p. (In Russ.)

Avlyayev G. O., Sanchirov V. P. Medieval ethnic Oirats of Dzungaria: Origins of Torghuts and Khoshuts revisited. In: Issues of Kalmyk Ethnogenesis. Elista, 1984. Pp. 43–58. (In Russ.)

Baatar Ubashi [Tyumen]. A History of the Four Oirats. BIBLIOTHECA OIRATICA–II. B. Tuvshintogs, Na. Sükhbaatar (eds., etc.). Ulaanbaatar, 2006. 180 p. (In Russ.)

Badmaev A. V. (comp., ed.) The Moonlight: Historical and Literary Monuments of the Kalmyks. Elista. Kalmykia Book Publ., 2003. 477 p. (In Russ.)

Batmaev M. M. The Kalmyks, 17th–18th Centuries: Events, Personalities, Household Life. Elista: Kalmykia Book Publ., 1993. 381 p. (In Russ.)

Belikov T. I. Kalmyks in the Peasants' War of 1773–1775. Elista: Kalmykia Book Publ., 1971. 167 p. (In Russ.)

Buvaev L. B., Dzhevkaev S. S., Ochirova N. G., Belousov S. S. et al. My Dear Ketchenery. Jubilee edition. Elista, 2008. 180 p. (In Russ.)

Dumas A. Travel Impressions in Russia. Vol. 3. Moscow: Ladomir. 638,[1] p. (In Russ.)

Hyacinth (Bichurin N. Ya.). A Historical Survey of the Oirats (or Kalmyks): From the 15th Century AD to the Present. Elista: Kalmykia Book Publ., 1991. 128 p. (In Russ.)

Khalmg Ünn. 2010, November 25. No. 216–217. Pp. 10. (In Russ.)

Kostenkov K. I. (comp.) Kalmyk Nomads of Astrakhan Governorate: Historical and Statistical Accounts Supplemented with a Map of Kalmyk Steppe. St. Petersburg: Ministry of State Property; N. Glybov, 1870. 170 p. (In Russ.)

Mandzhieva B. B. (comp.) Genealogies of Iki-Tsokhor Khoshuts Collected by Shanya V. Boktaev. Elista: Kalmyk Humanities Research Institute (RAS), 2011. 326 p. Ser. 'Treasures of Ancestors'. (In Russ. and Kalm.)

Mitirov A. G. Oirats – Kalmyks: Centuries and Generations. Elista: Kalmykia Book Publ., 1998. 384 p. (In Russ.)

Mitirov A. G. The Roots. Elista: Kalmykia Book Publ., 2002. 272 p. (In Russ.)

Nebolsin P. Kalmyks of Khoshoutovsky District: Essays on Everyday Life. St. Petersburg: K. Kray, 1852. 192 p. (In Russ.)

Palmov N. N. Kalmyks within Russia's Borders: Historical Essays. Astrakhan: Kalmyk State Publ. House, 1922. 137 p. (In Russ.)

Palmov N. N. Kalmyks within Russia's Borders: Historical Materials. Elista: Kalmykia Book Publ., 2007. 464 p. (In Russ.)

Sanchirov V. P. Ethnic structure of the Oirats, 15th–18th centuries: Analyzing data from *Iletkhel Shastir*. In: Historical Accounts of Precapitalistic Relations in Kalmykia. Elista, 1977. Pp. 11-18. (In Russ.)

Shantaev B. A. Kalmyk Khoshuts: A historical insight. In: Mandzhieva B. B. (comp.) Genealogies of Iki-Tsokhor Khoshuts Collected by Shanya V. Boktaev. Elista: Kalmyk Humanities Research Institute (RAS), 2011. 326 p. Ser. 'Treasures of Ancestors'. (In Russ. and Kalm.)